Хавсралт 2

## Магистрын сургалтын элсэгчдэд тавигдах шаардлага

<table>
<tr><th>Зүйл</th><th>Төрийн албан хаагч (Англи хэл)</th><th>Хувийн хэвшил (Япон хэл)</th></tr>
<tr><td>Иргэншил</td><td colspan="2">Монгол улсын иргэн байх</td></tr>
<tr><td>Нас</td><td colspan="2">2019 оны 4-р сарын 1 -ний байдлаар 25-39 настай байх<br>(1979 оны 4-р сарын 2-ноос 1994 оны 4-р сарын 1-ний хооронд төрсөн байх)</td></tr>
<tr><td>Боловсролын байдал</td><td colspan="2">Монгол улсын болон гадаад орны магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд бакалаврын зэрэг хамгаалсан байх<br>(Бүрэлдэхүүн хэсэг 1-2-2 буюу Кюүшүгийн их сургуулийн хуулийн тэнхимд өргөдөл гаргах элсэгч нь хуулийн чиглэлээр бакалаврын зэрэг горилсон байвал давуу талтай.)</td></tr>
<tr><td>Ажил байдал</td><td>• Монгол улсын төрийн байгууллагын үндсэн албан хаагч байх (Хөрөнгийн Биржээс бусад төрийн өмчит компаниуд хамрагдахгүй)<br>• Өргөдлийн маягт хүлээж авах эцсийн өдрийн байдлаар 2-оос дээш жил үндсэн албан хаагчаар ажилласан байх</td><td>Өргөдлийн маягт хүлээж авах эцсийн өдрийн байдлаар дараах байгууллагуудын аль нэгт 2-оос дээш жил үндсэн ажилтнаар ажилласан байх:<br>1. Монгол - Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төвийн бизнесийн Үндсэн сургалт болон Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх, оношилгоо, зааварчилгааны хөтөлбөр сургалтад ажилчдаа хамруулсан байгууллагын үндсэн албан хаагч байх<br>2. Жайкагаас хэрэгжүүлж буй “Жижиг, Дунд Үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл” -ийн зээлд хамрагдсан компаний үндсэн албан хаагч, эсвэл уг зээлийн үйл ажиллагаанд оролцож буй арилжааны банкны үндсэн албан хаагч байх<br>3. Монгол улсн Төрийн өмчит компаний үндсэн албан хаагч байх<br>4. Монголд үйл ажиллагаа явуулж буй Япон компаний үндсэн албан хаагч байх<br>5. Японы засгийн газрын тэтгэлэг (Монбүшо)-р Япон улсад бакалаврын зэрэг хамгаалсан, дээр дурдсан байгууллагуудаас бусад компаний үндсэн ажилтан байх (Бизнесийн удирдлага, эдийн засгийн чиглэлээр суралцсан бол давуу талтай)<br>* Дээрх 1), 2), 5), д хамаарах байгууллагууд нь Монголын болон Японы компаниуд байвал давуу талтай.</td></tr>
<tr><td>Хэлний чадвар</td><td>Англи хэл дээр магистрантурт суралцаж чадахуйц Англи хэлний өндөр мэдлэгтэй байх. (TOEFL iBT 61 (ITP 500) / IELTS 5.5 ба түүнээс дээш байвал сайн, заавал оноо шаардахгүй)</td><td>Япон хэл дээр магистрантурт суралцаж чадахуйц Япон хэлний өндөр мэдлэгтэй байх. (Япон хэлний түвшин тогтоох шалгалтын N1 түвшин, эсвэл J-Test-ийн 700 ба түүнээс дээш байвал сайн. )</td></tr>
<tr><td>Эрүүл мэнд</td><td colspan="2">Бие махбодь, сэтгэл зүйн хувьд эрүүл байх.</td></tr>
<tr><td>Хамрагдах боломжгүй хүмүүс</td><td colspan="2">• Одоогийн байдлаар тэтгэлэгт хамрагдаагүй, цаашид өөр тэтгэлэгт хамрагдахаар төлөвлөөгүй байх<br>• Гадаадын болон дотоодын тэтгэлэгээр магистрын зэрэг горилоогүй байх.<br>• Цэргийн зэрэг цолтой албан хаагчид хамрагдах боломжгүй. (Цэргийн алба хааж байгаа болон түр чөлөөлөгдсөн байгаа хүн хамрагдах боломжгүй.)</td></tr>
</table>

| | |
|---|---|
| Бусад | • Эрүүл мэндийн үзлэгт хамруулах явцад бүх шинжилгээнд хамрагдаж чадаагүй бол сонгон шалгаруулалтаас хасагдана. (Жишээ нь, цээжний рентген зураг гэх мэт)<br>• Сүүлийн сонгон шалгаруулалтад оролцохдоо “сургуулиа төгсөөд Монгол улсдаа буцаад ирэхэд нь байгууллагадаа буцааж ажиллуулах тухай” баталгааны бичгийг байгууллагын удирдлагаасаа авч ирүүлэх шаардлагатай.<br>• Тус тэтгэлэгээр суралцахаар болсон тэнцэгчид нь "Амлалтын бичиг" -ыг бөглөх шаардлагатай бөгөөд тус бичигт “JDS төгсөгчид нь Монгол Улсыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахын тулд төгсөж ирээд, хоёроос доошгүй жилийн хугацаанд амлалтын бичиг дэх үүргээ биелүүлж, өмнө нь ажиллаж байсан байгууллагадаа ажиллана” гэж заасан байна.<br>• JDS оюутнууд нь хөтөлбөрийн зорилгыг сайтар ухамсарлан, суралцаж төгсөөд буцаж ирэн, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах чин хүсэл эрмэлзэлтэй байх. |